



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар Б/04

Модот

Шагнаж урамшуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.23, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, Аймгийн Засаг даргын 2025 оны А/649 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн байгууллагын Архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах, үзлэгийг зохион байгуулахад идэвхи санаачлагатай ажиллаж, амжилттай 92,6%-тай үнэлэгдсэн тул сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ү.Ичинхорлоог сарын үндсэн цалингийн 20 хувиар шагнасугай.

2.Дээрх зардалд зарцуулагдах хөрөнгийг цалин сангийн зардлаас тооцож олгохыг Санхүү албаны Нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Засаг даргын орлогч (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ